



МОНГОЛ УЛСЫН  
ГЭГЭЭРЛИЙН САЙДЫН ТУШААЛ

1998 оны 08 сарын 17 өдөр

Дугаар 190

Улаанбаатар хот

Гадаадад сургах тухай

**ТУШААХ НЬ:**

1. Содовсүрэнгийн Наранчимэгийг АНУ-ын Орегон мужийн АУИС-д, сувилахуйн мэргэжлээр нэг жил, Гончигдоржийн Уянгахишигийг ХБНГУ-ын Бонн хотын Их Сургуульд эрх зүйн мэргэжлээр нэг жил, Шажинбатын Ариунааг ХБНГУ-ын Билефельдийн их сургуульд философйн мэргэжлээр нэг жил хагасын хугацаагаар 1998/1999 оны хичээлийн жилээс эхлэн магистрантурт тус тус суралцуулсугай.

2. Пүрэвжалын Баясгаланг ОХУ-ын Москва хотын Зам Харилцааны Их Сургуульд 1998 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс 4 сарын хугацаатай мэргэжил дээшлүүлэхийг зөвшөөрсүгэй.

3. Гэгээрлийн сайд, Сангийн сайдын 1998 оны 67/131 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй орнуудын магистрантур, аспирантур, докторантурт суралцагсадын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу С.Наранчимэг, Г.Уянгахишиг, Ш.Ариунаа нартай гэрээ байгуулж, холбогдох төлбөр тооцоо хийх, П.Баясгалангийн асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэхийг Сургалтын төрийн сан /Б.Ганбат/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлогнын хэрэгжилтийг зохицуулах газар /С.Алтангэрэл/-т тус тус даалгасугай.

САЙДЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ч. САЙХАНБИЛЭГ